

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ

2019 оны 07 дугаар
сарын 26 -ны өдөр

Дугаар А/152, А/366

Улаанбаатар
хот

Журам, жагсаалт батлах
тухай


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 157 дугаар зүйлийн 157.2 дахь хэсэг, 255 дугаар зүйлийн 255.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хүнд өвчтэй хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журам, жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /Д.Дамдинцэрэн/, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал /Д.Батжаргал/, Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Аймгийн эрүүл мэндийн газрын захирал, дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Билгүүн/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бямбадорж/-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 416 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Эрүүл мэндийн сайдын 2019 оны
.....А.152, А.166 дугаар хамтарсан
тушаалын нэгдүгээр хавсралт

ХҮНД ӨВЧТЭЙ ХОРИГДОЛД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар хүнд өвчтэй хоригдолд /цаашид “хоригдол” гэх/ эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх үйл ажиллагаанд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, тэдгээрт нийцүүлэн баталсан тогтоол, журам, эмчилгээ, оношилгооны стандарт, заавар болон энэхүү журмыг баримтална.

Хоёр. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх

2.1.Хорих анги нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий стандартын шаардлага хангасан хүний нөөц, багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан хэсэгтэй байна.

2.2.Хорих ангийн эмч анхны тусламжийн болон амилуулах суурь тусламжид шаардлагатай багаж хэрэгсэл, эм, тариагаар хангагдсан байна.

2.3.Хорих анги нь хоригдлын эрүүл мэндийн даатгалын дэвтрийн бүрдлийг хангаж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хугацаанд шимтгэлийг төлнө.

2.4.Хорих ангийн эмнэлгийн мэргэжилтэн нь Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжид заасан эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд мэргэжлийн ёс зүйг чанд баримтлан хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

2.5.Хоригдолд хүнд өвчний шинж илэрсэн тохиолдолд хорих ангийн захиргаа Хорих ял эдлүүлэх албаны нэгдсэн эмнэлэгт /цаашид “нэгдсэн эмнэлэг” гэх/ мэдэгдэж, хоригдлын биеийн байдлыг харгалзан ажлын 5 хоногийн дотор “Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дэглэм”-д заасан журмын дагуу шилжүүлнэ.

2.6.Хоригдлын эрүүл мэндийн байдлаас шалтгаалан шилжүүлэх боломжгүй тохиолдолд нэгдсэн эмнэлгийн эмнэлэг хяналтын комисс /цаашид “Эмнэлэг хяналтын комисс” гэх/ хорих ангид очиж үзлэг хийн дүгнэлт гаргана.

2.7.Эмнэлэг хяналтын комисс нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан дараах бүрэлдэхүүнтэй комисс

байх ба шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмчийг бүрэлдэхүүнд оруулж болно.

- 2.7.1. ерөнхий эмч;
- 2.7.2. эмчилгээ эрхэлсэн орлогч;
- 2.7.3. мэс заслын тасгийн эрхлэгч;
- 2.7.4. мэдрэлийн тасгийн эрхлэгч;
- 2.7.5. дотрын тасгийн эрхлэгч;
- 2.7.6. онош зүйн тасгийн эрхлэгч;
- 2.7.7. нарийн бичгийн дарга.

2.8. Эмнэлэг хяналтын комисс нь хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтоохоос бусад эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах болон Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/214, А/462 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хоригдлыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх журам”-ын 2.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.9. Нэгдсэн эмнэлэг энэ журмын 2.5-д заасны дагуу шилжиж ирсэн хоригдолд “Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дэглэм”-д заасны дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.


Гурав. Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх

3.1. Нэгдсэн эмнэлэгт шилжиж ирсэн хоригдол үзлэг шинжилгээний дүнд ялаас чөлөөлөх өвчнөөр өвчилсөн нь тогтоогдвол эмчлэгч эмч энэ тухай үнэн зөв баримтыг бүрдүүлж эмнэлэг хяналтын комисст даруй шилжүүлж, танилцуулна.

3.2. Эмнэлэг хяналтын комисс нь энэ журмын 3.1-д зааснаар шилжүүлсэн баримтыг үндэслэн энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалт”-ын 2.4-т заасан шинжилгээ, оношилгоог нягтлан шалгаж, бүрэн бүрэлдэхүүнээрээ хоригдлын биеийн байдалтай танилах бөгөөд дүнг хурлаар хэлэлцэж санал нэгдвэл хурлын тэмдэглэлд бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан, ялаас чөлөөлөх санал, эрүүл мэндийн тодорхойлолтыг хоригдлын хувийн хэрэг, ялын тооцооны хамт прокурорт хүргүүлнэ.

3.3. Прокурор энэ журмын 3.2-т заасны дагуу шилжүүлсэн баримтыг хянан үзэж саналыг үндэслэлтэй гэж үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.7 дугаар зүйлд заасны дагуу шинжээчийн дүгнэлт гаргуулна.

3.4. Зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтан, баривчлагдсан этгээд ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчнөөр өвчилсөн бол харьяа эмнэлгийн байгууллагын Эмнэлэг хяналтын комисс болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлтийг үндэслэн эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, баривчлах төв, байрны захиргаа ял, баривчлах шийтгэлээс чөлөөлүүлэх саналаа прокурорт хүргүүлнэ.



**ХОРИХ, ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ, НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ
ХИЙЛГЭХ ЯЛ, БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨХ
ӨВЧНИЙ ЖАГСААЛТ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүгийн хуулийн 6.13 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 37.7 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 157, 255 дугаар зүйлийг тус тус үндэслэн хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс өвчний учир чөлөөлөх үйл ажиллагаанд энэхүү жагсаалтыг ашиглана.

**Хоёр. Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял,
баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалт**

2.1. Баривчлагдсан этгээд, хоригдол дор дурдсан өвчнөөр хүнд өвчилж эд эрхтэний эргэшгүй өөрчлөлт орсон үед ялаас чөлөөлөх өвчнөөр өвдсэн гэж үзнэ.

2.1.1. цусны эсийн хорт хавдар;

2.1.2. цус төлжихгүй болсон цус багадалт;

2.1.3. үргэлжилсэн уналт, таталтын байдал /эпилепси статус/, хоёроос дээш эмэнд дасалтай эпилепси;

2.1.4. Лайеллын хам шинжийн үеийн олон эрхтний хурц дутмагшил;

2.1.5. холбогч эдийн тогтолцооны өвчний хүндрэл, эрхтэн тогтолцоонд гүнзгий өөрчлөлт гарах;

2.1.5.1. ясны бүтцийн эмгэгүүд /хүнд хэлбэрийн ясны сийрэгжилт, яс зөөлрөлт, Пежет болон Бехтеровын өвчин.

2.1.6. үе барьцалдсанаас өөртөө үйлчилж чадахгүй болсон /Окороковын үйл ажиллагааны ангилалын III үе, Бейнклерийн ангилалын IV үе/;

2.1.7. олдмол ухаан тэнэгрэлийн хүнд хэлбэр /F00, F01, F02, F03/, оюуны гүнзгий хомсдол /F73/;

2.1.8. үлдэц шизофрени /сэтгэцийн нэгдмэл үйл задрах эмгэгийн тасралтгүй болон дефект улам нэмэгдэх хандлагатай үе үе хөдлөх шизофрени /F20.50, F20.51/;

2.1.9. хөгшрөлтийн улмаас өөртөө үйлчлэх чадвар алдагдсан, бусдын асрамжинд орсон;

2.1.10. тархи, нуруу нугас, хязгаарын мэдрэлийн дарагдал, үрэвслийн хүнд хэлбэр /бусдын асрамжинд орох/;

2.1.10.1.сөнөрөлд өртсөнөөс үүссэн хос, тал саа;
2.1.10.2.дөрвөн мөчийн саажилт;
2.1.10.3.аарцгийн үйл ажиллагааны хямрал /баас, шээс хоригдох эсвэл задгайрах/;

2.1.10.4.мэдрэл булчингийн даамжрах хатангаршил, байнгын асрамжинд орох;

2.1.10.5.мэдрэлийн удмын болон эргэшгүй эмгэг өөрчлөлтийн улмаас өөртөө үйлчлэх чадвараа алдан хүний асрамжинд орсон.

2.1.11.хоёр гар оролцон гурван мөч, эсхүл дөрвөн мөчийг өвдөг, тохойн үеэс дээгүүр тайрагдсан;

2.1.12.хоёр нүд сохрох;

2.1.13.өмөнгийн 3-4 дүгээр үе;

2.1.14.ясны идээт үрэвслийн улмаас эрүүг мэс заслаар авсан;

2.1.15.гэмтэл болон өвчний улмаас үүссэн амин эрхтний үйл ажиллагааны дутмагшил:

2.1.15.1.тархины комын байдалтай;

2.1.15.2.цусны эргэлтийн архаг дутмагшлын II-III үе;

2.1.15.3.амьсгалын архаг дутмагшлын II-III үе;

2.1.15.4.элэгний архаг дутмагшлын II-III үе;

2.1.15.5.бөөрний архаг дутмагшлын II-III үе;

2.1.15.6.гэдэсний архаг дутмагшлын шувтаргын үе /нарийн, бүдүүн гэдэсний архаг өвчний улмаас 21 хоногоос дээш хугацаагаар мэдээгүй суулгаж тураалын III-IV зэрэгт орсон бол/;

2.1.15.7.олон эрхтний архаг дутмагшил;

2.1.15.8.хүнд хэлбэрийн үжил.

2.1.16.сүрьеэгийн хүнд хэлбэрүүд нь сүрьеэгийн эмчилгээний эсрэг заалт бүхий өвчнүүдтэй хавсарсан тохиолдол:

2.1.16.1.хурц шар болон элэгний циррозийн ээнэгшил алдагдсан үе;

2.1.17.сүрьеэгийн менингитийн улмаас мөчдийн саажилт үүссэн өвчтөн бусдын асрамжид орох;

2.1.18.хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ)-ийн халдварын IV үе шат (ДОХ) дараах өвчний амь насанд аюултай үе шат хавсарсан:

2.1.18.1. ДОХ уялдаат өвчин;

2.1.18.2.дагалдах халдвар;

2.1.18.3.суурь өвчин.

2.1.19.Хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан.

2.2.Энэ жагсаалтын 2.1.19 дэх заалт нь зөвхөн нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтанд хамаарна.

2.3.Зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөхөд энэхүү жагсаалтын 2.1.1, 2.1.3, 2.1.4, 2.1.12, 2.1.13, 2.1.14, 2.1.15.2, 2.1.15.3, 2.1.15.6, 2.1.18-д заасан өвчнүүд хамаарахгүй.

2.4.Энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан өвчнийг дараах шинжилгээ, оношилгоогоор баталгаажуулна.

д/д	Өвчний нэр	Шалгуур
1.	Цусны эсийн хорт хавдар	<ul style="list-style-type: none"> Гематологийн шинжилгээнд залуу эсүүд гарах Цус, чөмөгний түрхэцийн шинжилгээ
2.	Цус төлжихгүй болсон цус багадалт	<ul style="list-style-type: none"> Цусны түрхэц шинжилгээ /+/ ЦЕШ
3.	Үргэлжилсэн уналт таталтын байдал, хоёроос дээш эмэнд тэсвэртэй epilepsi	<ul style="list-style-type: none"> Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг ЭКГ Толгойн КТГ Хүчил шүлтийн тэнцвэр Тархины цахилгаан бичлэг /агшин болон унталтын үеийн/
4.	Лайеллын хам шинжийн үеийн олон эрхтний хурц дутмагшил	<ul style="list-style-type: none"> Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, дүгнэлт SCORTEN шалгуураар өндөр эрсдэлтэй
5.	Холбогч эдийн тогтолцооны өвчний хүндрэл, эрхтэн тогтолцоонд гүнзгий өөрчлөлт гарах <ul style="list-style-type: none"> ясны бүтцийн эмгэгүүд /хүнд хэлбэрийн ясны сийрэгжилт, яс зөөлрөлт, Пежет болон Бехтеровын өвчин. 	<ul style="list-style-type: none"> Эрхтэн тогтолцоог үнэлэх лабораторийн болон багажийн шинжилгээ Имунологийн эсрэг бие шинжилгээ Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, дүгнэлт Давамгайлан гэмтсэн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг үнэлэх нарийвчилсан шинжилгээ, төрөлжсөн мэргэжлийн үзлэг, дүгнэлт Рентген шинжилгээ Hla-b27, DEXA, CPR шинжилгээ
6.	Үе барьцалдсанаас өөртөө үйлчилж чадахгүй болсон үе /Окороковын үйл ажиллагааны ангилалын III үе, Бейнклерийн ангилалын IV үе/	<ul style="list-style-type: none"> Үений рентген зураг Үений КТ, шаардлагатай бол MRI Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, дүгнэлт Ясны нягтын шинжилгээ
7.	Олдмол ухаан тэнэгрэлийн хүнд хэлбэр / F00, F01, F02, F03/, оюуны гүнзгий хомсдол /F73/	<ul style="list-style-type: none"> Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг Эмгэг сэтгэл судлалын шинжилгээ Шаардлагатай тохиолдолд тархины багажийн шинжилгээ /КТГ, MRI, рентген зураг/ Шүүх сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээний үнэлгээ, дүгнэлт
8.	Үлдэц шизофрени /сэтгэцийн нэгдмэл үйл задрах эмгэгийн тасралтгүй болон дефект улам нэмэгдэх хандлагатай үе үе хөдлөх шизофрени /F20.50, F 20.51/	<ul style="list-style-type: none"> Шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээний үнэлгээ дүгнэлт Эмгэг сэтгэл судлалын шинжилгээ Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг

9.	Хөгшрөлтийн улмаас өөртөө үйлчлэх чадвар алдагдсан, бусдын асрамжид орсон	<ul style="list-style-type: none"> • Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг • Настны бие даах чадварын Катзын үнэлгээ • / 9-0 балл / • Настны багаж хэрэгсэлтэй ажиллах чадварын Лавтоны үнэлгээ /13-6 балл / • Настны сэтгэцийг үнэлэх хураангуй сорил буюу 30 онооны ММЕТ /13-6 балл/ • Настны сэтгэл гутралыг үнэлэх сорил, 15 асуулттай /5 ба түүнээс дээш оноо/
10.	<p>Тархи, нуруу нугас, хязгаарын мэдрэлийн дарагдал, үрэвслийн хүнд хэлбэр /бусдын асрамжид орох/</p> <ul style="list-style-type: none"> • сөнөрөлд өртсөнөөс хос, тал саа, • дөрвөн мөчийн саажилт, • аарцгийн үйл ажиллагааны хямрал /баас, шээс хоригдох эсвэл задгайрах • мэдрэл булчингийн даамжрах хатангаршил, байнгын асрамжинд орох; • мэдрэлийн удмын болон эргэшгүй эмгэг өөрчлөлтийн улмаас өөртөө үйлчлэх чадвараа алдан хүний асрамжинд орсон 	<ul style="list-style-type: none"> • Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг • Тухайн эрхтний КТГ • Нүдний уг харах • MRI шинжилгээ • Байнгын асаргаа шаардлагатай хүнийг үнэлэх шалгуур үзүүлэлт
11.	Хоёр гар оролцон гурван мөч, эсхүл дөрвөн мөчийг өвдөг, тохойн үеэс дээгүүр тайрагдсан	<ul style="list-style-type: none"> • Рентген зураг • Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, дүгнэлт
12.	Хоёр нүд сохрох	<ul style="list-style-type: none"> • Нүдний төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, шинжилгээ, дүгнэлт
13.	Өмөнгийн 3-4 дүгээр үе	<ul style="list-style-type: none"> • Хавдрын маркер • Эд, эсийн шинжилгээ • Тухайн эрхтний КТГ • Биохими • Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, дүгнэлт
14.	Ясны идээт үрэвслийн улмаас эрүүг мэс заслаар авсан тохиолдол	<ul style="list-style-type: none"> • Гавлын рентген зураг • Төрөлжсөн эмчийн үзлэг, дүгнэлт
15.	Гэмтэл болон өвчний улмаас үүссэн амин эрхтний үйл ажиллагааны архаг дутмагшил	<ul style="list-style-type: none"> • Холбогдох шинжилгээ, төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг • Комын байдлыг үнэлэхдээ: <ul style="list-style-type: none"> • Ухаан санааны үнэлгээ /3-8 балл/ • Цусны дэлгэрэнгүй шинжилгээ • Биохимийн үзүүлэлтүүд • Протромбины хугацаа • Цусны өсгөвөр • ЭКГ

		<ul style="list-style-type: none"> • Цээжний рентген зураг • КТГ • Нугасны ус • Хэвлийн хэт авиан шинжилгээ • Тархины доплер • Тархины цахилгаан бичлэг
16.	<p>Сүрьеэгийн хүнд хэлбэрүүд нь сүрьеэгийн эмчилгээний эсрэг заалт бүхий өвчнүүдтэй хавсарсан тохиолдол:</p> <ul style="list-style-type: none"> • хурц шар болон элэгний циррозийн ээнэгшил алдагдсан үе 	<ul style="list-style-type: none"> • Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, дүгнэлт • Хэвлийн ЭХО • Рентген зураг • ЦЕШ • Цэрний түрхэц • Микобактери илрүүлэх шинжилгээ • Биохими • Хепатитийн вирусийн маркер
17.	<p>Сүрьеэгийн менингитийн улмаас мөчдийн саажилт үүссэн өвчтөн бусдын асрамжид орох</p>	<ul style="list-style-type: none"> • Сүрьеэгийн эмчийн үзлэг • Мэдрэлийн эмчийн үзлэг • Рентген зураг • Тархи, нугасны шингэний шинжилгээ • ЦЕШ • Биохими
18.	<p>Хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ)-ийн халдварын IV үе шат (ДОХ) дараах өвчний амь насанд аюултай үе шат хавсарсан:</p> <ul style="list-style-type: none"> • ДОХ уялдаат өвчин • Дагалдах халдвар • Суурь өвчин 	<ul style="list-style-type: none"> • Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг • CD4 эсийн тоо • ХДХВ-ийн ачаалал • Бусад дагалдах халдварын лабораторийн шинжилгээ • ЦЕШ • Биохими • Хэвлийн ЭХО
19.	<p>Хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан</p>	<ul style="list-style-type: none"> • Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлт